



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
Төрийн Өмчийн Хувьцаат Компани

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 06 одор

Дугаар 104

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Олон
нийттэй харилцах үйл ажиллагаанд
баримтлах бодлогын баримт бичиг
батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, Компанийн дүрмийн 9.9.6, 9.9.11 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Олон нийттэй харилцах үйл ажиллагаанд баримтлах бодлогыг хавсралтаар батласугай.

Хоёр. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга М.Гантөгст даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  П.БАТ-ЭРДЭНЭ

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2014 оны 01 сарын 06-ны
өдрийн 04 тоот тушаалын хавсралт

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Зорилго

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн аливаа байгууллага болон олон нийттэй харилцах харилцаа холбоог сайжруулах, уг ажлын хүрээнд төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх, улмаар төр-байгууллага-хэвлэл мэдээллийн хэрэгсэл-олон нийт хоорондын мэдээ мэдээлэл солилцох уялдаа холбоог хангаж төрөөс батлагдсан бодлого шийдвэр, эрх зүйн актын хүрээнд өөрийн байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг нийгмийн эрх ашигт нийцүүлэн олон нийтэд хүргэж компанийн олон нийттэй харилцах үйл ажиллагааг үр ашигтайгаар хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

1. “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаар олон нийтэд мэдээллийг үнэн бодитой, шуурхай, хүртээмжтэйгээр өргөн суваг ашилан түгээх, харилцан уялдаа холбоотой байлгах зорилгоор мэдээллийн тасралтгүй байдлыг ханган ажиллана.
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хууль, , Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль /, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэг эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг баримтлан ажиллана.
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны нэгж болох “Шинэ төмөр зам” төслийн үйл ажиллагааг дотоодод болон Олон улсад сурталчилан тайниулах, мэдээллийн ил тод, тэнцвэртэй байдлыг хангах, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор олон нийтэд хандсан үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.
4. “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийг ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхлэн явуулагч байгууллагаас ялган таниулах, бие даасан онцлог шинж, нийгмийн статусыг тодорхойлж, олон нийтэд танил болгох, өөрийн байр суурийг нийгэмд өндрөөр тогтоох олон нийттэй харилцах бодлогын үндсэн зорилтыг ханган ажиллана.

Гурав. Олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлэх зарчим

1. Үндэсний язгуур эрх ашиг, улс төр, эдийн засгийн аюулгүй байдалд нийцүүлэх
2. Монгол Улсын төмөр замын тээврийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн заалтыг баримтлах
3. Монгол Улсын хэвлэл мэдээллийн эрх зүйн шаардлагад нийцүүлэн ажиллах
4. Нийгмийг мэдээллээр хангах, иргэдэд ойлгуулах, тэднийг нэгтгэх

5. Олон нийтийн санаа бодолд нөлөөлж, тэдний сонирхол дэмжлэгт тулгуурлан нэр хүнд есгех
6. Харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд эерэг харилцааг төлөвшүүлэн хадгалах зорилготой үйл ажиллагаа явуулж олон нийтийн санаа бодлын талаарх ойлголт, мэдээллийг үндэслэн зөв шийдвэр гаргуулах, нийгмийн эрх ашигт нийцсэн бодлого явуулах, удирдлагын хандлагыг дэмжих, бодлого гаргагчид нөлөөлөх, цаашдын хөгжлийг тодорхойлох

Дөрөв. Хамтын ажиллагааны чиглэл

1. Дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах хамтын ажиллагаанд баримтлах зарчим
 - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах
 - Иргэн хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хүндэтгэх
 - Хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх
 - Мэдээллээр хангах үйл ажиллагаа нээлттэй байх
 - Нийгмийн ашиг сонирхолд нийцсэн мэдээ, мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах
 - Гүтгэлгийн чанартай, өрсөлдөгчийг илтэд дайрч доромжилсон компанийн нэр хүндэд харшилахуйц мэдээлэл өгөхгүй байх
 - Байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулах зорилгоор захиалгат нэвтрүүлэг, нийтлэл, мэдээллийг дамжуулах.
2. Гадаад улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллахад Монгол Улсын холбогдох хууль, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зам, тээврийн сайдын баталсан тушаал болон байгууллагын дүрэм журам, олон нийттэй харилцах бодлого, чиглэлийг баримтална.
3. Төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд баримтлах зарчим
 - 3.1. Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах хамтын ажиллагаанд баримтлах зарчим
 - Дээд шатны байгууллагууд /Зам, тээврийн яам, Төрийн өмчийн хороо/-тай хамтран ажиллах ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл, тайлан бэлтгэж өгөх
 - Дээд шатны байгууллагуудын цахим хуудас, олон нийтийн хуудсаар дамжуулан компанийн холбогдолтой мэдээ мэдээллийг тогтмол хүргэх
 - Эдгээр байгууллагатай салшгүй уялдаа холбоог хангаж баримтлах бодлого, хөтөлбөр зэргийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх
 - 3.2. Ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллатай ажиллах зарчим
 - Ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, харилцан мэдээлэл солилцох уялдаат байдлыг хангаж, туршлага солилцох
 - Тухайн байгууллагаас өөрийн ялгарах онцлог, статусыг тогтоож, үндсэн үйл ажиллагааны талаар өргөн хүрээний мэдлэгийг олон нийтэд төлөвшүүлэх
 - 3.3. Олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай ажиллах зарчим

- Сэтгүүл зүйн салбарт нэр хүнд бүхий, хэвлэл мэдээллийн бодлогын нөлөөллийн судалгааг тогтмол явуулж дүн шинжилгээ хийн, үр дүнд хяналт шинжилгээ хийх чиглэлээр мэргэшсэн “Хэвлэлийн хүрээлэн” зэрэг байгууллагатай тогтмол хамтран ажиллах
- Тус компанийн зүгээс нийгэмд хэрэгжүүлж буй олон нийттэй харилцах бодлого, түүний хэрэгжилт, үр нөлөөг судлах шинжлэх, сайжруулан шинэчлэх арга хэмжээ авах талаар мэдээлэл солилцон зөвлөгөө авах, судалгаа гаргах.

Тав. Олон нийттэй харилцах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зүй

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг захиалгат болон захиалгат бус хэлбэрээр тогтмол нэвтрүүлэх
- Захиалгат болон захиалгат бус мэдээллийн шинж чанартай нэвтрүүлэг, нийтлэл, ярилцлага, баримтат кино, дурс бичлэгийг олон нийтийн мэдээллийн суваг ашиглан түгээх
- Компанийн үйл ажиллагааны талаар мэдээ мэдээллийг агуулсан хэвлэмэл хуудас, тараах материал, гарын авлага зэргийг тогтмол шинэчлэн бэлтгэх, олны хүртээл болгох
- Цахим мэдээллийн сувгуудыг ашиглан тогтмол мэдээ, мэдээлэл түгээх, хүлээн авагчийн тоог олшруулах, уншигчийн санал сэтгэгдэлд дүн шинжилгээ хийх
- Олон нийтэд чиглэсэн танилцуулга үйл ажиллагаа, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, форум зэргийг тогтмол зохион байгуулах
- Олон нийтэд чиглэсэн энтертайнмент үйл ажиллагаа явуулах
- Хандивын бодлого, нийгмийн хариуцлагатай холбогдуулан үйл ажиллагаа зохион байгуулах
- Мониторинг шинжилгээг тогтмол явуулж компанийн талаарх мэдээ, мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах.

Зургаа. Мониторинг хийх аргачлал

6.1. Мониторинг хийх төрөл

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулагдаж буй өдөр тутмын мэдээ, мэдээлэл, нийтлэл нэвтрүүлэг
- Байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, үйл ажиллагааны талаарх олон нийтийн сэтгэгдэл
- Өрсөлдөгч байгууллага, тэдгээрийн талаар хэвлэл мэдээллээр гаргасан нийтлэл, материал
- Төмөр зам, дэд бүтцийн салбарын холбогдолтой мэдээ мэдээлэл.

6.2. Мониторинг хийх аргачлал

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтэрч буй мэдээ мэдээллийн эх сурвалж, баримт нотолгоо, давтамж зэргийг судлаж, нэгтгэсэн мониторинг судалгааг улирлаар нэгтгэх, тайлагнах
- Олон нийтийн санаа бодол, компанийн талаарх сэтгэгдлийг мэдээллийн цахим хуудсууд дахь санал сэтгэгдлээр дүгнэх
- Өрсөлдөгч байгууллагын талаарх мэдээ мэдээллийн давтамж, эх сурвалж, агуулгат судалгаа хийх, улирлаар нэгтгэн танилцуулах

- Салбарын холбогдолтой мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, нэгтгэх, тайлагнах.

6.3. Мониторингийн үр дүнг гаргах, арга хэмжээ авах, асуудлыг шийдвэрлэх

1. Компанийн олон нийттэй харилцах харилцаанд тулгарч буй эерэг, сөрөг талыг тодорхойлох
2. Удирдлагыг мэдээллээр тогтмол хангах
3. Байгууллын үйл ажиллагаатай холбогдолтой олон нийтэд хүрэх мэдээ мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах

Дөрөв. Сөрөг мэдээ, мэдээлэлд мониторинг хийх

1. Байгууллагын үйл ажиллагааны эрх ашиг, нууцын журмыг зөрчиж хувийн ашиг сонирхлын үүднээс гутгэн доромжлохыг завдсан хувь хүн, бүлэг этгээдэд хариуцлага хүлээлгэх, хуулийн байгууллагад хандаж нэр төрөө сэргээлгэх
2. Тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр запруулга нийтлүүлэх
3. Сөрөг мэдээлэлд хариу мэдэгдэл бэлтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нэвтрүүлэх.

Долоо. Нэмэлт, өөрчлөлт

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн өөрчлөлт, шинэчлэл түүнтэй холбоотой дүрэмд өөрчлөлт орсон тохиолдолд энэхүү бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралд танилцуулж Гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

---оОо---